


СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

А. Лувсандэндэв.ШУА-ийн сурвалжлагч гишүүн,
профессор.**ХҮРЭЛ ТАМГЫН УЧИР**

Япон улсын Нагасаки мужийн Такашима арлын Урашима буланд живсэн Монголын Юан улсын хаан Хубилайн цэргийн онгоцыг Токиогийн их сургуулийн профессор Торао Мозаи олж, эртний судлалын шинжилгээ хийж байна. Японы эрдэмтдийн олсон олон тооны ваар сав, монгол сэлэм, тутрага чанадаг төмөр сав, хүрэл бурхан зэрэг эд өлөгийн зүйлийн дотор дөрвөлжин үсэгтэй хүрэл тамга байсны бичгийг уншиж өгнө үү хэмээн уул тамгын гэрэл зургийг над илгээжээ.

Тамгын гэрэл зураг, мөн тэрчлэн Японы эрдэмтдийн хийсэн тодорхойлолтоос үзвэл уул тамга дөрвөлжин хэлбэртэй, гонзгой дөрвөлжин бариултай, нүүр талын урт өргөн нь 6,5 см, зузаан нь 1,5 см, бариулын урт нь 4,4 см, өргөн нь 4 см, зузаан нь 1,2 см байна. Тамгын хүнд нь 550 гр ажээ.



Зураг

Тамгын ар талын баруун этгээдэд «Жиюаны 14 (1277) оны есөн сард цутгав» гэж хятадаар бичжээ. Үүнээс үзвэл «1281 онд Японд довтолсон монголчуудын усан онгоцны үлдэгдлийг олсон гэдэгтээ итгэж байна» гэж профессор Т. Мозаигийн хэлсэн нь нотлогдож байна.¹ Үнэхээр Хубилай хаан Японыг 2 удаа, 1274, 1281 онд цэрэглэсэн билээ.

¹Ричард Билл. Усанд шумбагчид Хубилай хааны усан онгоц олсон байна» «Геральд Трибун» 1980—12—16-ны дугаарт.

Тамгыг 1277 онд хийсэн гэж нэгэнт бичээстэй байгаа учир онгоцны үлдэгдэл Хубилай хааны сүүлчийн аян дайнд хамаатай нь гарцаагүй болж байна.

Тамгын зүүн этгээдэд таван утга үсэг байсны 1,3,5-р нь баларч, 2-р нь мэдэгдэж байна. Энэ нь эртний үед kün дуудлагатай байсан, орчин үед цзюнь гэсэн дуудлагатай, «цэрэг» гэсэн утгатай үг байна. 4-р нь ра гэсэн дуудлагатай утга үсэг байна.

1-р үсгийг японы эрдэмтэд сэргээсэн нь захирах гэсэн утгатай үсэг эртний дуудлага нь kuan, орчин үеийн дуудлага нь гуань байна. 3-р үсгийг японы эрдэмтэд сэргээжээ. Энэ нь эртний үед tsuong дуудлагатай байсан, орчин үед цзун дуудлагатай бөгөөд дараачийн ра үсэгтэй нийлээд tsuongra гэсэн цэргийн түшмэлийн нэр болж байна. Монголын Юан улсын Хубилай хааны үед мянгатын ноёны дараа ордог цэргийн түшмэлийн ийм албан тушаал буй болгосон² бөгөөд монголоор багцат гэдэг билээ. Энэ нь зуу-гэдэг үндсэнд үг бүтэх-т дагавар залгаж зуут гэдэг нэр томъёо гаргасны жишээгээр багц гэдэг үндсэнд-т дагавар залгаж үүсгэжээ.


Тавдугаар үсгийг нь Японы эрдэмтэд сэргээсэн нь дундад эртний үед ien орчин үед инь гэсэн дуудлагатай тамга гэсэн утгатай үг байна.

Ийнхүү тамгын ар талын зүүн этгээдэд kuan kun tsuong pa ien гэсэн «цэрэг захирах багцатын тамга» гэсэн утгатай үг болж байна. Гэвч Японы эрдэмтдийн тайлбараас үзэхэд тэд «бүх цэргийг ерөнхийлөн захирагч тамга» гэсэн утгаар ойлгосон байж ч магадгүй байна.

Тамгын нүүр талд Монголын дөрвөлжин үсгийн бичээс байгааг Японы эрдэмтдийн илгээсэн гэрэл зургийн дардаснаас латин галиг хадаж сийрүүлбэл:

а) Уул тамгын дардасны баруун этгээдэд:

Зураг




Уг тамгын дардасны зүүн этгээдэд:

³Юан улсын судар (хятад хэвлэл) 98-р дэвтэр. Цэрэг-1.

⁴“China Daily” November 1, 1981

Үүнийг XIII зууны үеийн дуудлагаар галиглавал: gon gūn гэсэн үг болно.

Үүнийг мөн үеийн дуудлагаар галиглавал: junba yin гэсэн үг болж байна.



Зураг

үсэг нь дөрвөлжин бичгээр хятад хэлээр бичихэд хэрэглэдэг үсэг болно. gon гэдэг нь дунд эртний үед kuan гэж дуудаж байсан, эдүүгээ гуань гэж дууддаг «засгийн газрын, улсын» гэсэн хятад үг бололтой. Энэхүү уг тамганы ар талын зүүн этгээдийн нэгдүгээр үсгийн илтгэсэн үгтэй адил үг буй за. gūn гэдэг нь уул тамганы ар талын зүүн этгээдийн цэрэг гэсэн утгатай 2-р үсэг даруй мөн буй за. Эдгээр хоёр үг нийлээд gon gūn «засгийн газрын цэрэг» гэсэн утгатай холбоо үг болж байна.

zunba гэдэг нь өмнө дурдсан tsuongra мөн бөгөөд Юан улсын сударт тэмдэглэсэн байна.³ Японы эрдэмтдийн сэргээсэн, тамгын ар тальш зүүн этгээдийн 3-р үсэг үүнтэй утга адил ажээ. yin гэдэг нь тамгын ар талын зүүн этгээдийн тавдугаар үсгээр илтгэсэн хятад хэлний тамга гэсэн уг даруй мөн.

Ингээд gon gūn zunba yin гэдгийг монгол хэлнээ орчуулбал «Засгийн газрын цэргийн багцатын тамга» гэсэн үг болж байна. Энэ баримт уг тамгыг Хубилай хааны цэргийн тэргүүн удирдагчдын нэгний нь тамга⁴ мэтээр үзэх явдал үндэсгүйг харуулж байна.

Урьдын цагт аливаа тамгыг үйлдсэн эд уул тамгын зэрэг дэвийг илтгэж байв. Хаш тамгыг үлэмж эрхэмд үздэг байжээ. Мэдээжийн хэрэг ихэс дээдсийн тамгыг алт мөнгөөр үйлдэж байв. Доогуур тушаалын түшмэдийн тамгыг хүрэл, модоор хийдэг байсан билээ. Тамгын зэрэг дэвийг тодорхойлоход бариулын хэлбэр бас учир холбогдолтой билээ. Ихэс дээдсийн тамгын бариулыг тэмээ, арслан, барс, яст мэлхий зэрэг амьтны дүрстэй хийдэг заншилтай байв.

Юан улсын сударт «алтан тамга гөрөөсөн бариулт» (108.5), «алтан тамга тоймог луу бариулт» (108.26), «алтан тамга тэмээний бариулт», (108-34), «алтан шарсан мөнгөн тамга тэмээний бариулт» (108-21) «алтан шарсан мөнгөн тамга яст мэлхийн бариулт» (108.44), «мөнгөн тамга яст мэлхийн бариулт» (108.46), гэх зэрэг мэдээ буй нь үүнийг тодорхой гэрчилж байна.

Ийнхүү тамгыг үйлдсэн эд, бариулын хэлбэр, тамга дээр сийлсэн үсгийг үндэс болгон Японы эрдэмтэн Торао Мозаи нарын олсон хүрэл тамга бол Монголын Юан улсын цэргийн багавтар түшмэл, мянгатын даргын удаа орох ноёны тамга мөн гэсэн дүгнэлт хийхэд алдаа болохгүй буй за. Гэвч тамгын ач холбогдол нь том түшмэлийн тамга уу, бус уу гэдэгт орших бус гэдгийг дурдалтай байна.

Хубилай хааны зарлигаар, Монгол улсад багтсан эрээвэр хураавар олон угсааны ард түмний алины нь ч хэлэнд тохирох тийм нийтлэг цагаан толгой Пагва лам зохиосон нь дөрвөлжин бичиг билээ. Дөрвөлжин бичгийг 1269 оноос XIV зууны наяд он хүртэл албан хэрэгт нэлээд өр-

³Юан улсын судар (хятад хэвлэл) 98-р дэвтэр. Цэрэг-1.

⁴“China Daily” November 1, 1981

гэн хэрэглэж бансан юм. Дөрвөлжин бичгээр ном зохиол хэвлэж байсны ул мөр ч эдүүгээ олдож байгаа юм. Японы эрдэмтдийн олсон дөрвөлжин бичгийн тамга бол Монголын хаад Хятадын утга үсэгт бичгийг халж, авианы үсэгт бичигтэй болгох улс төрийн бодлого явуулж байсны баримт гэж үзвэл зохино. Хэрэв Хубилай хааны энэ бодлого биелсэн бол феодалын нийгмийн нөхцөлд хятад ястан нь харилцан бие биетэйгээ өрсөлдсөн хэдэн ястан болон задарч, Монголын феодал ангн хятадын ард түмнийг боолчлон дардах нэгэн нөхцөл болж өгөх байлаа. Хубилай хааны Хятадын ард түмний эсрэг ийм нарийн бодлого явуулж байсны нэгэн ноттой баримт бол Японы эрдэмтдийн олсон хүрэл тамга юм. Түүхэн үнэн ийм байна.

О БРОНЗОВОЙ ПЕЧАТИ ПОДТЫСЯЧНИКА ХУБИЛАЯ

Резюме

Среди археологических находок почетного профессора Токийского университета Торао Мозаи была бронзовая печать, с вытесненными на ней, знаками квадратного письма текстом. Было доказано, что печать была отлита в 1277 году и принадлежала одному из офицеров войск Великого хана Хубилая.

Текст написанный на китайском языке, транслитерированный в квадратное письмо гласит: «Печать подтысячника правительственных войск» Квадратное письмо было создано Пагбаламой в 1269 году и широко применялось вплоть до 80-х годов XIV столетия. Император Хубилай проводил политический курс на введение фонетической письменности для китайского языка взамен иероглифической. Целью этого курса было создание облегчающих условий для эксплуатации китайского народа монгольскими ханами.

Нынешнее китайское руководство для претворения в жизнь великоханьского шовинизма не останавливается перед возвеличиванием монголтэских ханов, даже несмотря на то, что их политика была направлена против китайского народа. Провозглашением Хубилая национальным героем Китая, пекинские лидеры ставят целью наследовать его агрессивную политику и насаждать идеи великоханьского шовинизма и гегемонизма.